



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

“Эхлэл их наяд” ХЗХ-нд салбар нээн ажиллуулахыг зөвшөөрөх  
болон төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх  
үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5, 13.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 5.1, 5.4, 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эхлэл их наяд” ХЗХ-нд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3, 4, 7 дугаар хороодын нутаг дэвсгэрт тус тус салбар нээж ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Эхлэл их наяд” ХЗХ-нд төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2014 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор хийлгэхийг “Эхлэл их наяд” ХЗХ /Н.Болд/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН